



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 577

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 29 нэрийн нийт 76,497,140.00 (далан зургаан сая дөрвөн зуун ерэн долоон мянга нэг зуун дөчин) төгрөгийн балансын үнэ, 3,500,000.00 (гурван сая таван зуун мянган) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Ц.Орхончимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталсан бага оврын тракторыг сургалтын дадлагын хичээлд сэлбэгээр ашиглах, эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001534

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн  
.....<sup>577</sup> дугаар тогтоолын хавсралт



Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Трактор /бага оврын пад трактор/	2012.12.19	1	5,818,000.00	5,818,000.00	0.00
2	Суурин компьютер / dell i5/	2016.06.01	24	1,227,490.00	29,459,760.00	0.00
3	Зөөврийн компьютер / dell i5/	2016.06.01	5	1,595,110.00	7,975,550.00	0.00
4	Өнгөт принтер	2016.06.01	2	721,820.00	1,443,640.00	0.00
5	Проекторын цагаан самбар 200*150,100	2016.06.01	2	118,140.00	236,280.00	0.00
6	Олон үйлдэлтэй принтер /samsung MFP SL-2870 FD	2016.06.01	1	517,550.00	517,550.00	0.00
7	Энгийн принтер /canon LBP-6030/	2016.06.01	3	209,990.00	629,970.00	0.00
8	LCD проектор	2016.06.01	3	720,830.00	2,162,490.00	0.00
9	Багш ширээ	2010.09.01	1	127,900.00	127,900.00	0.00
10	Шилэн ширээ	2011.09.07	1	169,900.00	169,900.00	0.00
11	Багш ширээ	2011.09.07	1	199,900.00	199,900.00	0.00
12	Багш ширээ	2011.09.05	5	258,000.00	1,290,000.00	0.00
13	Багш ширээ	2010.08.25	2	182,000.00	364,000.00	0.00
14	Босоо шкаф	2010.11.01	1	453,700.00	453,700.00	0.00
15	Буйдан	2010.12.01	1	759,000.00	759,000.00	0.00
16	Дугуйтай сандал	2010.10.01	3	178,100.00	534,300.00	0.00
17	Сандал /залгаа хар/	2011.09.17	1	374,000.00	374,000.00	0.00
18	Түшлэгтэй сандал	2010.12.20	6	65,600.00	393,600.00	0.00
19	Шүүгээ Түмбочик	2011.11.07	2	269,800.00	539,600.00	0.00
20	Эмийн шүүгээ	2012.09.08	1	369,900.00	369,900.00	0.00
21	Шүүгээ	2011.09.08	1	174,900.00	174,900.00	0.00
22	Шилтэй шкаф саарал	2010.11.01	1	301,800.00	301,800.00	0.00
23	Шилтэй шкаф шар	2010.10.01	2	278,400.00	556,800.00	0.00

24	Шкаф	2011.06.23	3	289,900.00	869,700.00	0.00
25	Шкаф	2011.09.17	1	314,900.00	314,900.00	0.00
26	Хурлын угтвар ширээ	2012.06.28	1	2,070,000.00	2,070,000.00	0.00
27	Э-твэт программ	2016.03.01	1	14,500,000.00	14,500,000.00	0.00
28	Ситиэс НББ программ	2016.07.25	1	390,000.00	390,000.00	0.00
29	Чацарганы мод	2017.9.10	1000	3,500.00	3,500,000.00	3,500,000.00
	<b>Нийт дүн</b>		<b>1,077</b>		<b>76,497,140.00</b> (далан зургаан сая дөрвөн зуун ерэн долоон мянга нэг зуун дөчин)	<b>3,500,000.00</b> (гурван сая таван зуун мянган)